

2026 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсад малчин, туслах малчид нь улирлын шинжтэй, байгаль цаг уурын эрсдэл өндөр нөхцөлд өөрөө хөдөлмөр эрхэлдэг онцлогтой бөгөөд тэдний орлого тогтмол бус байдаг. Нийгмийн даатгалын одоогийн зохицуулалт нь шимтгэлийг сар бүр төлөхөөр тусгасан нь малчин, туслах малчдын бодит хөдөлмөрийн нөхцөл, орлогын мөчлөгтэй нийцэхгүй байна. Үүний улмаас нийгмийн даатгалд хамрагдалт тасалдах, тэтгэврийн эрх бүрэн хангагдахгүй байх бодит эрсдэл үүсэж байна. Энэхүү хууль батлагдсанаар малчин, туслах малчин нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байгаа нөхцөл арилж сайн дурын үндсэн дээр нийгмийн даатгалаа төлөх нөхцөл бүрдэх юм.

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах...”, мөн хуулийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;”, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1-д “Амьдралын баталгаа хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ” гэж заасан.

Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны”-ны зорилт 3.1.2-т “Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж заасан.

1.2. Практик шаардлага

Малчин, туслах малчдын нийгмийн даатгалын хамрагдлыг нэмэгдүүлэх, шимтгэл төлөлтийг бодит орлогын нөхцөлтэй уялдуулах нь Үндсэн хуулиар баталгаажсан нийгмийн хамгаалал, шударга байдлын зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Олон улсын туршлагаас үзэхэд хөдөө аж ахуйн салбарт өөрөө хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан уян хатан нийгмийн даатгалын шимтгэлийн тогтолцоо нь нийгмийн даатгалын тогтвортой байдлыг хангах үр нөлөөтэй болох нь нотлогдсон.

Иймд малчин, туслах малчдын онцлогт нийцсэн, уян хатан, сонголттой зохицуулалтыг хуульчлах зайлшгүй шаардлага бий болсон.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зорилго нь малчин, туслах малчдын нийгмийн даатгалд хамрагдах боломжийг бодитойгоор нэмэгдүүлэх, шимтгэл төлөлтийг нөхцөлд байдалд нийцүүлэх, улмаар малчин, туслах малчны нийгмийн хамгааллын баталгааг хангахад оршино.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж дараах харилцааг тусгана:

- Малчин, туслах малчин нийгмийн даатгалын шимтгэлийг улирлын шинж чанартай орлоготой уялдуулан жилд хоёр удаа хуваан урьдчилан төлөх боломжийг тусгасан;
- Малчин, туслах малчин нийгмийн даатгалын шимтгэлийн хуваан төлөлт болон хугацааг гэрээгээр харилцан тохиролцож төлөх боломжийг хангах эрх зүйн зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар эдийн засгийн хувьд малчин, туслах малчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бодит ачаалал буурч, шимтгэл тасалдах эрсдэл багасахын зэрэгцээ нийгмийн даатгалын сангийн орлого тогтворжих эерэг үр дагавар бий болно.

Нийгмийн үр дагаврын хувьд малчин, туслах малчдын нийгмийн даатгалд хамрагдах идэвх нэмэгдэж, тэтгэврийн эрхийн баталгаа сайжрах, улмаар хөдөөгийн хүн амын нийгмийн хамгаалал бодитоор дээшилж, ахмад настны ядуурал, нийгмийн эрсдэл буурах эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хууль зүйн үр дагаврын хувьд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн давтамж, хэлбэрийн сонголт нэмэгдсэнтэй холбогдуулан хүний эрхийг хангах тогтолцоо бүрэлдэнэ.

Эдгээр арга хэмжээг цогцоор хэрэгжүүлснээр хуулийн төслийн зорилго бодитой хэрэгжиж, эдийн засаг, нийгэм, хууль зүйн эерэг нөлөө бий болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг болон Үндсэн хуулийн суурь зарчимтай бүрэн нийцүүлэн боловсруулах бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно. Мөн хүний эрхийг хангах тогтолцоог бий болгох зорилготой тул Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц болон хууль тогтоомжтой нийцнэ.

---o0o---